



## БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 02 сарын 26 өдөр

Дугаар А/95

Булган сум

Эрүүл мэндийн салбарын эмч, эмнэлгийн  
мэргэжилтнүүдэд сургалт зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, 66 дугаар зүйлийн 66.1, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны II/04 дүгээр тогтоолоор батлагдсан “Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 1.1.2.4 дэх заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны IV/03 дугаар тогтоолоор батлагдсан “Эрүүл мэнд” хөтөлбөр, аймгийн Засаг даргын 2024 оны А/32 дугаар “Хөтөлбөр, төлөвлөгөө, арга хэмжээний зардлыг батлах тухай” захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Эрүүл мэндийн салбарын эмч, эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, харилцаа, хандлагыг сайжруулах сургалтын удирдамжийг 1 дүгээр, төсвийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Сургалт зохион байгуулахад шаардлагатай 359,000 (гурван зуун тавин есөн мянга) төгрөгийг “Эрүүл мэнд” хөтөлбөр арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газар (Д.Алтаншагай)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА БАРИУН-ЭРДЭНЭ



Аймгийн Засаг даргын 2024 оны  
02 дугаар сарын 26-ны өдрийн А.196 дугаар  
захирамжийн 1 дүгээр хавсралт

**“МЭРГЭЖЛИЙН ЁС ЗҮЙ, ХАРИЛЦААНЫ УР ЧАДВАР”  
СУРГАЛТЫН УДИРДАМЖ**

**Удиртгал:** Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлж буй мэргэжилтний амин чухал зүйл нь хүнтэй харилцах чадварыг мэргэжлийн түвшинд эзэмших явдал юм. Харилцааны ур чадварын талаарх мэдлэг дутмаг байдлаас үүдэн эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх явцад алдаа, дутагдал гаргах, үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийг бууруулах, түүнийг шийдвэрлэх арга дутах явдал эрүүл мэндийн байгууллагад ажиллаж буй эмч, мэргэжилтнүүдийн дунд элбэг тохиолдож байна.

**Зорилго:** Эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах харилцаа, хандлага, ёс зүйн хэмжээг сайжруулах, нотолгоонд суурилж хөгжих арга зүйг эзэмшүүлэхэд оршино.

**Зорилт:** 1. Асуудал тодорхойлох, хандлага, зан үйл, эерэг хандлагын мөн чанар, харилцааны хүрээнд хэрхэн мэдлэг эзэмшиж, хэвшүүлэх аргачлалд суралцах;

2. Эрүүл мэндийн ажилтанд тавих ерөнхий шаардлага, үйлчлүүлэгчийн сэтгэлд хүрсэн тусламж үйлчилгээ үзүүлэх, түүнд нөлөөлөх хүчин зүйлсийг тодорхойлох судалгааны арга зүй эзэмших;

**Сургалт зохион байгуулах бүрэлдэхүүн:** Д.Отгонсүрэн–Эрүүл мэндийн газрын Эмнэлгийн тусламж, үйлчилгээний хэлтсийн мэргэжилтэн

Б.Мөнгөнчимэг - Аймгийн Нэгдсэн эмнэлгийн Сувилахуйн албаны дарга

**Сургалтын удирдан зохион байгуулах багш нар:** С.Наранчимэг–Анагаах ухааны доктор, профессор

С.Нармандах – Сувилахуйн ухааны докторант

**Сургалт зохион байгуулагдах огноо:** 2024 оны 03 дугаар сарын 1-ний өдөр 10:30 цагаас эхэлнэ.

**Сургалт явагдах газар:** Аймгийн Засаг даргын Тамгын газрын хурлын танхимд

**Сургалтын агуулгын багтаамж:** 1 багц цаг (ЭМХҮТ-вебэд суралцагч мэргэжилтнүүд бүртгүүлж, баталгаажуулна)

**Сургалтын хэлбэр:** Танхимын (Лекцийн PPT, семинар, бие даан суралцах материалаар хангана (аудио, видео, PPT видео, PDF), оролцооны аргаар зохион байгуулагдана.

**Сургалтын агуулга:**

1. Эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэхэд хандлага, харилцаа, үнэт зүйл, хүндэтгэлийн талаар мэдлэг эзэмших

2. Мэргэжилтний ёс зүй эзэмших пирамид буюу үе шат, зарчимтай танилцах

3. Сайхан харилцахад эрүүл мэнд нөлөөлөх нь

4. Харилцааны ур чадвар, түүнд нөлөөлөх хүчин зүйл: 55%, 38%, 7%-ийн дүрэм

5. Сэтгэлд нийцсэн үйлчилгээ эерэг хандлагад суурилдаг

6. Нотолгоонд суурилж хөгжих арга зүй - Үйлийн судлаач болохын ач тус

Аймгийн Засаг даргын 2024 оны  
02 дугаар сарын 26-ны өдрийн А/95 дугаар  
захирамжийн 2 дугаар хавсралт

**АЖЛЫН БАЙРНЫ ДАДЛАГА СУРГАЛТЫН ТӨСӨВ**

Д/д	Шаардагдах зардал	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт
1	2	3	4	5	6
1.	Багш нарын байрлах зочид буудал	Хоног.хүн	2	80000	160,000
2.	Шатахуун (дизель)	Литр	50	3980	199,000
	Дүн				<b>359,000</b>